

**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ  
БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ  
ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 03 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч шүүх шинжилгээний нийтлэг журмыг боловсронгуй болгох, шинжилгээний хэлбэр, төрлийг шинэчлэн тодорхойлох, шинжилгээний мэдээллийн сан, төрөл, бүрдүүлэлт, ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчин бий болгох, мөн хүрээлэн байгаа орчны хохирол болон сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийн хэмжээг тооцох аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн тогтоох, шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох зэрэг зорилгоор Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар хохирогчийн сэтгэцэд учирсан хохирлыг хэрхэн тооцдог талаар болон мөнгөн дүнгээр тооцож хохирол барагдуулсан тохиолдол байгаа эсэх, хуулийн төсөлд заасан хохирогчийн сэтгэцэд учирсан хохирлыг тооцох аргачлалын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил шүүхийн шинжилгээний байгууллагын хараат бус байдлыг хэрхэн хангах талаар болон сэтгэцэд учирсан хор уршиг, сэтгэл санаанд учирсан хохирлын талаар, зориуд худал дүгнэлт гаргасан шинжээчид тооцох хариуцлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг шүүхийн шинжилгээний байгууллага цаашид ямар статустай байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид цагдаагийн байгууллагын цолтой байх нь зохистой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлыг тооцох зохицуулалтыг анх оруулж ирж байгааг дэмжиж, шүүхийн шинжилгээний байгууллага нь хараат бус шинжлэх ухааны байгууллага байх талаар, мөн сэтгэцэд учирсан хор уршиг, сэтгэл санаанд учирсан хохирлын талаарх ойлголтыг хэлэлцүүлгийн явцад нарийвчлан зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг шүүхийн шинжилгээний байгууллагын хараат бус байдал болон цаашид олон улсын итгэмжлэгдсэн байгууллага болоход анхаарах, мөн байгууллагын алба хаагчдын чадавхын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж, шүүхийн шинжилгээний байгууллагын хараат бус ажиллах нөхцөлийг бүрдүүлж, чадавхыг нэмэгдүүлэх нь зүйтэй талаар санал хэлсэн болно.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтооолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтооолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Л.МӨНХБААТАР

